

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 05 дугаар сарын 01-ээс 31-ний өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 1844 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 1304 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 540 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн хилийн боомтод 282 гадаадын иргэнд зохих ангиллын, төвд 2 гадаадын иргэнд олон удаагийн Монгол Улсын виз олгосон. Мөн 3 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олгож, 2 иргэний визийн шилжүүлэг хийлээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
1304	540	284	429	1076	0	175	127
1844							

05 дугаар сард нийт 488 аж ахуйн нэгж, байгууллагын 1891 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.


“evisa.mn” цахим системээр нийт 33 улсын 1327 иргэнд цахим виз олгож, 3 улсын 3 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 429 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 1076 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 238 иргэний бүртгэлд хасалт хийлээ. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 33 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 36 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 175 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 127 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 60,6 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 40,8 хувиар тус тус өсөж, виз олголт 44,1 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 16,0 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 867 ширхэг шинээр хэвлэж, 692 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 45 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 105 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 2 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 3939 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
3151	347	63	342	36	3939

Визийн зөвшөөрлийн дугаар бүхий имэйлийг 915 иргэн, хуулийн этгээдэд илгээж, 1079 гадаадын иргэнд оршин суух үнэмлэх олгосноос хүргэлтийн үйлчилгээгээр 10 иргэнд үйлчилсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 111 иргэнд, утсаар 138 иргэнд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар нийт 7 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 1 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
05 дугаар сар	-	-	-	17
2022 он /өссөн дүнгээр/	1	-	-	176

Түүнчлэн 14 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 11 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлээ. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад Улс	-	-	-	1	-
	нийт	-	-	-	1	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	7	-	-	13	11
	нийт	7	-	-	13	11
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	1	-	-
	нийт	-	-	1	-	-

Монгол Улсын харьяатаас гарч бусад улс (Бүгд Найрамдах Австри Улсын харьяат болох 5, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын харьяат болох 2)-ын харьяат болохоор 7 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4077 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 17 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 3)

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 2 байгууллагын хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, 1 байгууллагад тодорхойлолт олгож, 1 байгууллагын дүрмийн өөрчлөлтийг мэдээллийн санд бүртгэсэн.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтээ хугацаандаа гаргаагүй Америкийн Нэгдсэн Улсад төвтэй “Монголын Андууд” төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрлийг хүчингүй болгох тухай сонсох ажиллагааг 05 дугаар сарын 20-ны өдөр явууллаа.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/874 дүгээр, мөн сарын 23-ны өдрийн 01/944 дүгээр албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй.

Төлөвлөгөөт бус 29 удаагийн хяналт шалгалтыг 51 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 57 иргэнийг хамруулан зохион байгуулж, паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 5

Торгуулсан гадаадын иргэн						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-3.2	16.2-3.3		
1	Азербайжан	1			1	100000
2	Вьетнам	2			2	200000
3	Казахстан	-	1	1	2	4000000
4	Орос	2			2	200000
5	Өмнөд Солонгос	1			1	100000
6	Папуа-Шинэ Гвиней	1			1	100000
7	Тайланд	1			1	100000
8	Хятад	2			2	200000
9	Япон	1			1	100000
Нийт		11	1	1	13	5100000

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх зорилгоор ажиллуулж буй 70133448 дугаар утсаар дамжуулан ирүүлсэн 1 гомдол, мэдээллийг хүлээн авч, 1 улсын 1 иргэний баримт бичигт үзлэг шалгалт явуулахад зөрчил илрээгүй тул гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, сайн дураар зөрчил гаргаснаа илчилсэн 13 иргэнд холбогдох гомдлыг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.

Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн болон оршин суух хугацааг хэтрүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн нийт 9 улсын 13 гадаадын иргэн, 1 уригч аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу 9,210,000 төгрөг (Есөн сая хоёр зуун арван мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6)

Хүснэгт 6

Зөрчлийн мэдээ (тухайн сард)							
Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
13	5,100,000	1	1	4,110,000	-	-	-
нийт 9,210,000 төгрөг							
Үүнээс гадаадын иргэн							
Хуулийн үндэслэл	Шалтгаан				Торгуулийн хэмжээ (төгрөг)	Гадаадын иргэний тоо	
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн				1,100,000	11	
Зөрчлийн тухай хууль 16.2-3.2	оршин суух хугацааг хэтрүүлсэн				2,000,000	1	
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3	визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно				2,000,000	1	
нийт					5,100,000	13	

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэний Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд хариу тайлбар болон Бүгд Найрамдах Франц Улсын иргэний шаардлагад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хариу тайлбарыг тус тус гаргасан.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2 улсын 3 иргэнийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 7)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь заалтыг үндэслэн Бүгд Найрамдах Солонгос Улсын 1, Бүгд Найрамдах хятад Ард Улсын 4, Оросын Холбооны Улсын 1 буюу нийт 6 гадаадын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг байгууллагын даргын 5 удаагийн тушаалаар тус тус түдгэлзүүлсэн.

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сард)				
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл		Нийт
		37.1.2	37.1.8	
1	Вьетнам	2		2
2	Филиппин		1	1
	Бүгд	2	1	3

Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 7 улсын 31 иргэн, Агаарын замын боомт хариуцсан газар 1 улсын 1 иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаажээ.

График 2



05 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3,1 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 42,9 хувь, саатуулсан гадаадын иргэн 66,7 хувиар тус тус өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 66,7 хувиар буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тус байгууллагад холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн 1 дүгээр улирлын тайланг 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/938 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Хүний эрхийн үндэсний форум-2021”-д шүүх эрх мэдэл, хууль сахиулах салбарт өгсөн үүрэг даалгаврын байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах заалтын биелэлтийг 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/967 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

“Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 05 дугаар сарын 05-ны өдөр батлан хэрэгжилтийг хангаж байна.

Байгууллагын 05 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 05 дугаар сарын 03-ны өдөр баталж, 04 дүгээр сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг 05 дугаар сарын 10-ны өдөр нийт албан хаагчдад цахим (ep.e-mongolia.mn)-аар танилцуулав.

Байгууллагын 04 дүгээр сарын тайланг нэгтгэн боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/866 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтны орон тоо үүсгэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид тусгасан зохицуулалт, байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ, онц чухал мэдээллийн системийн ашиглалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой санал боловсруулав.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан сонгон шалгаруулалтад тэнцсэн 3 иргэнийг байгууллагын даргын Б/119, Б/120, Б/121 дүгээр тушаалаар тус тус тухайн албан тушаалд томиллоо.

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын тусгай сонгон шалгаруулалтыг Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Монгол Улсын төрийн дээд одон медальд нэр дэвшсэн 6 албан хаагчийн баримт материал, тодорхойлолтыг хурлын тэмдэглэлийн хамт 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/903 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Төрийн албаны зөвлөлөөс Канадын Засгийн Газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслийн хүрээнд “Сонгон шалгаруулалтад багаар ажиллах ур чадвар, хандлага, зан үйлийг тодорхойлох, ярилцлага зохион байгуулах” аргачлал, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 05 дугаар сарын 05,10-ны өдрүүдэд зохион байгуулж, салбар зөвлөлийн гишүүд болон холбогдох албан хаагч нийт 12 хүн оролцов.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдвээр 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан сургалтад нийт 140 албан хаагчийг хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг албан хаагчдад сурталчлах, борлуулах арга хэмжээг авч ажиллалаа.

“Үндсэн хууль ба нийгмийн хамаарал, Хууль зүйн хэрэглээ” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 06,13-ны өдрүүдэд цахим хэлбэрээр тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 400 албан хаагчийг оролцуулсан.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх зорилгоор зарим албан хаагчдыг лавлах утасны операторчоор бэлтгэх 2 дугаар ээлжийн сургалтыг 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлүүлж, орон нутаг дахь нэгжийн 6 албан хаагчийг бэлтгэж байна.

Англи хэлний дунд, гүнзгий шатны сургалтыг 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд 7 хоног тутам танхимаар зохион байгуулж, нийт 36 албан хаагч тус тус хамрагдсан.

Төрийн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох А3 сертификатын сургалтад 05 дугаар сарын 12-оос 14-ний өдрүүдэд 8 албан хаагч хамрагдан, үүнээс 1 албан хаагч сертификат эзэмшигч болж, 7 албан хаагч 05 дугаар сарын 26-аас 28-ны өдрүүдэд давтан сургалтад хамрагдлаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Тоон гарын үсгийн гэрчилгээ” олгох арга хэмжээнд нийт 94 албан хаагчийг оролцуулж, гэрчилгээжүүлсэн.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 15, цахим сүлжээнд 21 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 45 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (5 телевиз, 4 сонин, 36 сайт)-ээр сурталчилсан.

Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), eImmigration аппликэйшнд баяжилтыг хийж, байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж байна.

“Оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг тавдугаар сарын 09-ний өдрөөс зөвхөн цахимаар хүлээн авна”, “Визийн зөвшөөрлийн кодыг и-мэйлээр илгээж байна” зэрэг мэдээг Өдрийн сонин, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Eagle, ТМ телевиз болон нийт 21 сайтаар, байгууллагын үйл ажиллагаанд Call Pro системийг нэвтрүүлсэнтэй холбоотой 43 секундийн видео мэдээг тус тус олон нийтэд хүргэлээ.

Мөн цахим сайт peguun.mn-д Гадаадын иргэний зөрчлийн тухай мэдээлэл болон Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлсэн тухай” мэдээллүүдийг тус тус хүргүүлж ажиллав.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг байгууллагын даргын 05 дугаар сарын 03-ны өдрийн А/66 дугаар тушаалаар шинэчлэн батлав.

“НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын ээлжит 7 дахь удаагийн тайланд байгууллагын 2018-2021 оны хооронд гүйцэтгэсэн үндсэн үйл ажиллагаатай холбогдох судалгаа, тайланг 05 дугаар сарын 17-ны өдрийн 02/918 дүгээр албан

бичгээр, “Зөрчлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг 05 дугаар сарын 06-ны өдөр цахим хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

“Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам” болон “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын төсөлд саналыг 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/919 дүгээр албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэний нэхэмжлэлтэй Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох нотлох баримтыг 05 дугаар сарын 06-ны өдрийн “Хариу тайлбар хүргүүлэх тухай” 01/870 дугаар албан бичгээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүллээ.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгчтэй 05 дугаар сарын 02-ны өдөр албан уулзалт зохион байгуулж, цахим виз, хил орчмын аялал жуулчлалын виз, гадаадаас ажиллах хүч авах болон гадаадын хөрөнгө оруулагчдын оршин суух зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцсон.

Түүнчлэн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Гадаадын ажиллах хүч, цахим виз, хөрөнгө оруулалт хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал солилцох нь” сэдэвт уулзалтыг 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Уулзалтад Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллага, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, аялал жуулчлал, бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцов.

Бүгд Найрамдах Турк Улсад 05 дугаар сарын 23-аас 27-ны өдрүүдэд хийсэн албан айлчлалаар олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол, Туркийн Цагаачлал, шилжилт хөдөлгөөний байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр албан уулзалтуудыг зохион байгууллаа. Айлчлалын хүрээнд төлөөлөгчид Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (TIKA)-т зочлохдоо байгууллагад өрнөж буй цахим шинэчлэлийн хүрээнд мэдээлэл, технологийн шинэлэг шийдлүүдийг үйлчилгээнд нэвтрүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн.

Монгол Улс болон Оросын Холбооны Улсын консулын зөвлөлдөх уулзалтын зохион байгуулалттай холбогдуулан тус улсын харьяат иргэдийн баримт бичгийн зөрчил, амьдрах нөхцөлийн хүндрэлтэй байдлын талаарх мэдээллийг 05 дугаар сарын 17-ны өдрийн 09/54 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.3.2. Дотоод хяналт:

“Монгол сугалаа” ХХК-аас 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан “С1 телевиз” болон “Өлзий телевиз”-ийн шууд эфирийн хөтөлбөрт хөтлөгч нь Гадаадын иргэн, харьяатын газрын лого бүхий хар өнгийн цамц өмссөн асуудалд хийсэн хяналт шалгалтаар эх үүсвэрийг тогтоон, хариу арга хэмжээ авч ажиллалаа.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Хууль тогтоомжийн хүрээнд 18 албан хаагчид 84 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 14 албан хаагчид 208 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлсөн.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 15, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 25 буюу нийт 40 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 172 албан бичиг (хариутай 69)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд бүртгэлээр шилжүүлэн, нийт 168 албан бичгийг гадагш илгээсэн ба хяналтад 17 албан бичиг байна.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчаас төв байгууллагад 41 (иргэнээс 21, албан хаагчаас 20) өргөдөл, 3 гомдол, 2 хүсэлт, боомт, орон нутаг дахь нэгжид 43 (иргэнээс 15, албан хаагчаас 28) өргөдөл буюу нийт 84 өргөдөл, 3 гомдол, 2 хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 74 өргөдөл, 2 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 10 өргөдөл, 1 гомдол, 2 хүсэлт шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөл, гомдолгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

“Eimmigration” системийн хөгжүүлэлтийн хүрээнд виз сунгуулах хүсэлтийг цахимаар хүлээж авах болон хэрэглэгч шинээр бүртгүүлэхэд Yahoo mail-ээр бүртгэл үүсгэхгүй байх тохиргоог оруулав.

ХУР системд RNSF-н get_person сервисээс гаргаж буй мэдээлэлд passport_info-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж, холбогдох уулзалтыг зохион байгууллаа.

Зөвлөгөө мэдээллийн үйлчилгээний утасны 1800-1882 дугаарыг CallPro системд шилжүүлэн, тохиргоог хийж, системийг 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 5 шугамаар буюу төв газарт 2 цэг, боомт, орон нутаг дахь 3 газраас холбогдон дуудлага хүлээн авах боломжтойгоор зохион байгуулж, бүрэн ажиллагаанд оруулаад байна.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

05 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 4,226.8 сая төгрөгийн санхүүжилт авч 2,955.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарт тусгах саналыг 01/901 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн дагуу (өссөн дүнгээр) төсөв санхүүгийн 124 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 125 мэдээ, бусад 193 мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайтад байршуулсан.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд оны эхнээс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд (өссөн дүнгээр) 254.0 сая төгрөгийн орлого, 1305124929 тоот валютын дансанд 48975.76 ам.доллар буюу 256.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт орон нутаг дахь нэгжүүд нийт 403.0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлээд байна.

2.6.3. Худалдан авалт:

Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолборын барилгын ажил гүйцэтгэх гэрээг Сангийн яамны www.publicinvestment.gov.mn сайтын PIMIS программд байршуулсан.

2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай саналыг 01/902 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулахтай холбогдуулан байгууллагын даргын 05 дугаар сарын 11-ний өдрийн “Тооллогын комисс байгуулах тухай” А/68 дугаар тушаалыг баталж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу үзлэг тооллогыг эхлүүлээд байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхийн хүрээнд ашиглаж байгаа автомашины мэдээллийг 01/914 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Захиргаа, удирдлагын газарт зөөврийн компьютер 1 ширхэг, Мэдээллийн технологийн хэлтэст зөөврийн компьютер 2 ширхэг, Баруун бүс дэх газарт компьютер 2 ширхэг, Баян-өлгий аймаг дахь хэлтэст компьютер, принтер тус бүр 2 ширхэг олгосон.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны “Хаан шонхор-2022” гурав дахь удаагийн нэгдсэн дадлага сургуулийн арга хэмжээний зохион байгуулалтад зориулан байгууллагын байр, өрөө тасалгаа, зам талбайг бэлтгэлээ.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 04 дүгээр сарын статистик мэдээг 05 дугаар сарын 05-ны өдрийн 03/856 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 04 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээг мөн өдрийн 03/855, 03/857, 03/858 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх

газар, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж ажилласан.

Байгууллагын 05 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд урьдчилсан хяналт шинжилгээ хийж, холбогдох санал дүгнэлтийг бэлтгэн, 6 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан 04 дүгээр сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 92.9 хувиар үнэлсэн тайлан боловсрууллаа.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээг 05 дугаар сарын 01-ээс 31-ний өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хэлбэрээр нийт 21 удаа хүргүүлсэн.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

“2022 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г 05 дугаар сарын 09-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын даргын 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Дорноговь аймаг дахь газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, хууль, эрх зүйн хүрээнд гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийх тухай” 01-10/03 дугаар удирдамжаар хийсэн дотоод аудитын дүгнэлт, холбогдох саналыг 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-10/08 дугаар илтгэх хуудсаар танилцууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудаст байршуулсан 04 дүгээр сарын мэдээлэлд хяналт тавьж ажиллав.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам” шинэчлэгдсэнтэй холбогдуулан “Боомт, орон нутаг дахь нэгжийн ажиллах журам”-ыг байгууллагын даргын 05 дугаар сарын 30-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар шинэчлэн баталлаа.

“Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Агаарын тээврийг хялбаршуулах журам”-ын хагас жилийн хэрэгжилтийг Зөвлөлийн нарийн бичгийн даргын “Ажлын алба”-д 05 дугаар сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр, мөн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 05 дугаар сарын 12-ны өдрийн 03/894 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Орон нутаг дахь нэгжүүд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу хууль, эрх зүйн чиглэлээр дотооддоо нийт 12 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн төрийн бусад байгууллагуудаас хууль эрх зүй, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан нийт 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 199 албан хаагч хамрагдсан.

Боомтын өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд хилийн 8 боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг баталгаажуулав. Үүнд:

1. “Өрнөлпроект” ХХК-ийн гүйцэтгэсэн Дорнод аймгийн Хавирга боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 02-ны өдөр;
2. “Эй Ди И Пи” ХХК-ийн гүйцэтгэсэн Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 05-ны өдөр;

3. "Татах хүч" ХХК-ийн гүйцэтгэсэн Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 23-ны өдөр;
4. "Креатив Монголиа" ХХК-ийн гүйцэтгэсэн Дорноговь аймгийн Ханги боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 23-ны өдөр;
5. "Хайдро дизайн" ХХК-ийн гүйцэтгэсэн Говь-Алтай аймгийн Бургастай, Дорнод аймгийн Ульхан боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 23-ны өдөр;
6. "Артконстракшн" ХХК-ийн гүйцэтгэсэн Дорнод аймгийн Баянхошуу, Сүмбэр боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийг 05 дугаар сарын 24-ны өдөр тус тус баталгаажууллаа.

"Монгол бичиг-III" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Үндэсний бичиг, үсгийн баяр"-ыг тохиолдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын албан хаагчид "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-ийг монгол бичигт хөрвүүлснийг байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулж, олон нийтэд сурталчиллаа. Мөн Баруун бүс дэх газар албан өрөөнүүдийн хаягийг үндэсний бичигт хөрвүүлэн шинэчилж, нийт компьютерт монгол бичгийн үсгийн программ суулгажээ.

Баруун бүс дэх газар албаны байр барих барилгын шавыг 05 дугаар сарын 15-ны өдөр тавьлаа.

Баян-Өлгий аймгийн Цагааннуур хилийн боомтод ажиллах албан хаагчдын амьдрах байрны засварын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэвийн явагдаж байна.

Агаарын замын боомт хариуцсан газар Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадаас ажиллах хүч авч ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэдэд "Хууль тогтоомж, байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчлах өдөрлөг"-ийг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутаг дахь нэгжүүд нийт 272 мод тарьж, тогтмол усалгаа, арчилгааг хийж байна.

Тайлант хугацаанд орон нутаг дахь нэгжийн дарга нараас 25 тушаал (үндсэн үйл ажиллагаатай холбоотой 14, хүний нөөцтэй холбоотой 11) баталсныг бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг тооцон ажиллалаа.